

## SECURITY AT MUSEUMS МУЗЕЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ



## INTRODUCTION

– the following instructions are generally applicable in most circumstances.

– please note that the duties pictured here may be assigned to more than one guard.

– please remember that instructions issued by the Museum curator or other person in authority have priority over the indications of this manual.

– always trust your best experience, judgement and skill to handle unusual events or unforeseen circumstances.

## ТАНИЛЦУУЛГА

– зааврыг ерөнхийдөө ихэнх нөхцөл байдалд хэрэглэх боломжтой.

– зургаар үзүүлсэн үүрэг хариуцлага нь музейн хамгаалалтын нэг ажилтанд төдийгүй холбогдох бусад албадад хамаарна.

– эрх бүхий удирдлагаас батлан гаргасан заавар нь энэ гарын авлагын заавраас илүү хүчин төгөлдөр байх бөгөөд түүнийг зайлшгүй мөрдөнө.

– гэнэтийн болон урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүсэхэд танай байгууллагын туршлага мэдлэг чадвар илүү тустай гэдэгт итгэлтэй байх ёстой.



Museum protection duties never stop – the handover from night duty to daytime duty should be carried out according to agreed procedures, in an orderly and secure manner.

Музейг хамгаалах үүрэг хэзээ ч зогсдоггүй байнгын ажиллагаа юм. Тогтсон тусгай дэгийн дагуу нягт нямбай баталгаатай нөхцөлд өдөр шөнийн хамгаалалтын ээлжийн ажлыг хүлээлцэж байвал зохино.



Duty starts about half an hour before opening to the public; all emergency exits should be free and the immediate exit area inspected to remove possible obstructions.

Хамгаалалтын үйлчилгээтэй холбоотой үүрэгт ажил музей нээхээс хагас цагийн өмнө эхлэнэ. Юуны өмнө гэнэтийн аюул ослын үед ашиглах хаалгуудыг чөлөөтэй байлгаж, гарцуудыг сайтар шалгаж, саад тотгор болох зүйлүүдийг зайлуулна.



Open or unlock all windows and doors that have been secured at night.

Шөнийн цагт хааж хамгаалсан цонх хаалгуудын түгжээг тайлж, нээнэ.



Check that all important keys are present or properly accounted for.

Түлхүүрүүд хадгалсан байрандаа тоо ёсоор, бүрэн хэвийн байгаа эсэхийг шалгана.



Read any remarks written in the log-book and take appropriate steps if any.

Жижүүрийн мэдээний дэвтэрт бичсэн сүүлийн бүх мэдээллийг уншиж, шаардлагатай бол холбогдох арга хэмжээ авна.



Switch off night intrusion detection panel and check regular operation of closed circuit television system, portable alarm transmitter, portable radio sets, public address equipment, first aid kit and emergency equipment.

Шөнийн хяналтын самбарыг салгаж өдрийн хяналтын холболтуудад шилжүүлнэ. Дохиолол, мэдээллийн ба телевиз, радиогийн хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, мөн хүүхдэд зориулсан түргэн тусламжийн болон аврах техник хэрэгслийг шалгах хэрэгтэй.



Check the quality of the recorded images by replaying an accelerated video cassette or digital recorder.

Хяналтын камерын хуурцаг ба дижитал дүрс бичлэгүүдийн бичигдсэн байдал, чанарыг шалгах




Check your block note, pen, portable lamp and other personal equipment.

Мэдээний дэвтэр, үзэг, зөөврийн гэрэл зэрэг бусад хэрэгслүүдийг шалгана.



Inspect all artefacts on display and check that all are accounted for and secured.

Үзүүлэгт байгаа бүх үзмэрүүдэд үзлэг хийж, тоо ёсоор бүрэн бүтэн хэвээр байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.



If any artefacts are missing, check that the appropriate label, with duly authorized signature, is applied on site.

Зарим үзмэр түр хугацаанд байхгүй байгаа бол энэ тухай хариуцсан ажилтан гарын үсэг зурсан тайлбар бичиг байгаа эсэхийг шалгана.




Look for artefacts accidentally moved or in a dangerous position; **do not touch artefacts**. Ask a specialist to rectify the situation.

Үзмэр байнаасаа хөдөлж, гэмтэж болзошгүй байрласан байвал **үзмэрт шууд гар хүрч болохгүй**. Мэргэжлийн ажилтанд хандаж, засаж байрлуулахыг хүсэх нь зүйтэй.



Ask a specialist to rectify the situation; artefacts should always be moved by skilled people wearing gloves and taking special precautions.

Мэргэжлийн, дадлагажсан ажилтан урьдчилан сэргийлэх зааврыг мөрдөн бээлий өмсөж, үзмэрийг засч байрлуулна.



Please remember that water and fire are the two greatest risks in a museum.

Ус гал хоёр бол музейд хамгийн аюул эрсдэлтэй зүйл гэдгийг байнга санацгаая.



Look for possible water damage.

Усны аюул осол гарч болох эсэхийг шалгах хэрэгтэй.



Avoid large piles of flammable packing materials; inform supervisor and ask for them to be removed.

Галд хялбар асах зүйлүүдийг нэг дор овоолохоос болгоомжлохын тулд хяналтын ажилтанд мэдэгдэж овоорсон эд зүйлсийг зөөж зайлуулахыг хүсвэл зохино.




Check location of all portable extinguishers and ...

Гал унтраах хорны байршлыг шалгана.




... state of operation.

Гал унтраах хэрэгсэл ажиллуулахад бэлэн эсэхийг туршиж үзнэ.




Check location and state of fire alarm buttons.

Галын дуут дохионы бэлэн байдлыг шалгана.



Check electrical connection wires and report any faulty or damaged wiring immediately.

Цахилгаан утасны холболтуудыг шалгаж ямар нэг алдаа, гэмтэл илэрвэл яаралтай мэдээлнэ.




Check the contents of all first aid kits installed in the exhibition rooms.

Үзвэрийн танхимд байрлуулсан эмнэлгийн яаралтай тусламжийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгана.



Check that all internal phones are in working order.

Телефон утас ба тэдгээрийн холболтууд хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана.



Check the free field of vision of CCTV cameras.

Телевизийн нэгдсэн системийн дурангуудын хэвийн ажиллагааг шалгана.




Monitor cleaning operations and occasionally check contents of trash bins.

Цэвэрлэгээний байдлыг хянаж, хогийн сав доторхийг үзэж шалгана.



Report any bulbs that have blown.

Шатсан гэрлийн шилийг тэмдэглэж мэдэгдэнэ.



Fix minor disruptions, if possible, or report to appropriate service.

Жижиг гэлтгүй эвдэрч гэмтсэн болон сэжиг эргэлзээ төрүүлсэн зүйлийг олж илрүүлж, боломжтой бол холбогдох албанд мэдээлэх хэрэгтэй.



Check for any trash left on site and report to appropriate service.

Хог хаягдал байгаа эсэхийг шалгаж холбогдох хүмүүст мэдээлж байх шаардлагатай.



Carefully identify visiting scholars and third parties, before granting a visitor pass, to be constantly displayed while on museum premises.

Түр ажиллах судлаач, эрдэмтэд болон бусад хүмүүст музейд нэвтрэх үнэмлэх олгохоос өмнө сайтар судалж, таньж мэдэх нь чухал.



Closely monitor all loading and unloading operations.

Ачаа ачих, буулгах үеийн бүх ажиллагааг дэргэд нь байлцан үзэж шалгана.



Monitor and, if necessary, prevent activities, in immediate museum surroundings, that may be a source of danger – if appropriate, call police for help.

Музейн орчин тойронд аюулын эх үүсвэр болох зүйл байгаа эсэхэд сайтар үзлэг шалгалт хийх, шаардлага гарвал холбогдох арга хэмжээ авах, цагдаагийн тусламж хүсэх хэрэгтэй.



Monitor the activities of conservators, graphic artists and so on; if necessary, temporarily restrict access to the exhibition room where work is being performed.

Үзмэр арчлан хамгаалах ажилтан ба сэргээн засварлагч, зураачийн ажиллагаанд хяналт тавьж байх, шаардлага гарвал үзмэр байгаа өрөөнд хүн орохыг түр хязгаарлана.




If you use keys, giving access to showcases or other critical containers, do not let anybody handle the key on your behalf, or even see it.

Хэрэв та хорго ба бусад чухал зүйлийн түлхүүр хариуцсан бол бусдад түлхүүрээ шилжүүлж болохгүй бөгөөд үзүүлсэний ч хэрэггүй.



Profile keys may be easily copied by making a quick impression with wax or soap.

Хялбар хувилж болохуйц түлхүүрийг зориулалтын материалаар хэв авч музейд хадгалах шаардлагатай.



Even the codes of high security double bitted keys, used on safes, may be captured by a skilled observer.

Маш сайн хамгаалалттай сейф шүүгээний давхар далавчтай түлхүүрний шифрийг ч мэргэшсэн хүн хараад л мэдэж болно гэдгийг санаж байвал зүйтэй.



Be ready to open museum doors at stated time – it is an essential act of courtesy to visitors.

Музейг цагийн хуваарийн дагуу яг цагт нь нээж байх нь үзэгчдэд эелдэг хандаж байгаа маш чухал зүйл юм.




Gently but firmly, ask visitors to leave at the entrance all personal items that can cause damage to objects or may be used to hide and take these away.

Музейд орохдоо үзмэр гэмтээх эсвэл үзмэр нууж авч гарч болох эд зүйлээ үлдээж хадгалуулах шаардлагатай гэдгийг үзэгчдэд эелдгээр тайлбарлаж ойлгуулах хэрэгтэй.




A museum is a temple of our cultural heritage – do not let unruly or improperly dressed visitors desecrate it.

Музей нь бидний уламжлалт нандин өвийн ариун сүм ордон учраас зохисгүй, бохир хувцасласан хмүүсийг оруулахгүй байх нь зүйтэй.



Be ready to help disabled visitors, giving assistance and directions – be careful not to be distracted from your main duty which is to protect exhibits.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслалцаа үзүүлж, музей хэрхэн үзэх талаар чиглэл, мэдээлэл өгөх, ингэхдээ үзмэр хамгаалах гол үүргээ мартаж болохгүйг анхаарах нь чухал.



Keep an attentive eye on visitors during opening hours, to detect early signs of potential trouble or improper behaviour.

Музей нээлттэй байх үед гарч болох аюул, зүй бус үйлдлийг цаг тухайд нь илрүүлэхийн тулд үзэгчдийг байнга ажиглаж байх шаардлагатай.



Try to find a strategic observation point and move often, constantly taking different paths and at different times.

Нийтэд нь ажиглаж болохуйц газраас хянаж харж байх бөгөөд янз бүрийн цагт аль болох олон удаа явж эргэлт үзлэг хийх шаардлагатай.



It takes only seconds to damage a painting with a portable spray can, or...

Зөөврийн савтай шингэн зүйлээр уран зургийг гэмтээхэд хэдхэн хором зарцуулна гэдгийг санах хэрэгтэй.



... to scratch a valuable portrait.

Хоромхон хугацаанд ховор нандин зургийг сараачиж гэмтээж болно гэдгийг санах хэрэгтэй.



Prevent visitors from using flashes if photographing is authorized – explain that excessive light may irreversibly damage delicate organic-based colours and disturb other visitors.

Гэрэл цохиулж зураг авахаас сэргийлэх нь чухал. Хэрэв зөвшөөрөгдсөн бол цочмог хурц гэрэл нь органик бүтэцтэй хэврэг зүйлийн өнгийг гэмтээх, үзэгчдийн тав тухыг алдагдуулдаг гэдгийг үйлчлүүлэгчдэд тайлбарлах нь зүйтэй.



Prevent visitors from using tripods, during picture-taking (if authorized) – the tripod may interfere with the free flow of visitors and slow down rapid exit, in case of emergency.

Үзэгч (зөвшөөрөгдсөн бол) гэрэл зураг авахдаа тулгуур хөл хэрэглэхийг хориглох нь зүйтэй. Энэ нь үзэгчдийн хөдөлгөөний урсгалыг саатуулахаас гадна онцгой тохиолдолд шуурхай ажиллагаанд бэрхшээл учруулж, удаашруулж болох гэдгийг санах хэрэгтэй.



Do not let visitors touch artefacts of any kind – even metal can be damaged by corrosion from natural skin oils.

Үзэгчийг ямар ч үзмэрт гар хүрэхийг хориглох ёстой. Төмөр зүйл ч гэсэн хүний арьснаас ялгарах тосонд бохирдож гэмтэнэ.



Strictly enforce a no – smoking policy; fire is a major risk for artefacts displayed in a museum.

Галын аюул бол үзмэрийн гол гамшиг учраас музейд тамхи татахгүй байх бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай.



Gently yet firmly stop visitors from using exits which should be used only in emergencies.

Онцгой байдлын зориулалтын хаалгаар бусад үед үзэгч орж гарахыг хориглож, энэ тухай үзэгчдэд эелдгээр тайлбарлах хэрэгтэй.



Do not allow visitors to bring food and bottles into the museum; bottles may break and food may spill on museum floors.

Шилтэй зүйл хагарах, хүнсний зүйл асгарч болох учир музейд дээрх зүйлийг оруулахгүй байх нь зүйтэй.



Show visitors where they may eat and drink – check that trash is thrown in bins.

Үзэгчдэд хоол, хүнсний зүйл хэрэглэх, түр хадгалах газрыг зааж танилцуулах, хог хаягдлаа хогийн саванд хийсэн эсэхийг шалгаж сануулж байх нь зөв.



If you notice a suspicious bag or package in the museum ...

Хэрэв Та сэжигтэй бараа боодол музейд харвал...



... gently but firmly ask all visitors to leave, restrict access to the risk area and call for appropriate support.

Бүх үзэгчдэд музейгээс түр гарахыг зелдгээр, гэхдээ тууштай тайлбарлаж хүсэх, эрсдэлтэй талбайд хүн оруулахгүй байх арга хэмжээ авч холбогдох тусламж дуудах шаардлагатай.




Young visitors are the future custodians of our cultural heritage, but...

Залуу үзэгчид бол бидний соёлын өвийн ирээдүйн эзэд мөн. Гэхдээ...



... contact the school master, give advice and directions, discreetly monitor children's behaviour. If necessary, call for additional support.

... сургуулийн багштай нь уулзаж, музейг хүүхдүүдэд хэрхэн үзүүлэх талаар зөвлөмж мэдээлэл өгөх, тэдний хөдөлгөөнийг хянаж зохицуулах, шаардлага гарвал дэмжлэг болох ажилтнуудыг музейгээс ажиллуулах хэрэгтэй.



Watch for children and visitors chewing gum; often the gum is found attached to the underside of artefacts.

Бохь зажилж байгаа хүүхэд болон үзэгчийг сайтар анхаарах хэрэгтэй. Учир нь бохийг үзмэрийн аль нэг хэсэгт наалдуулах үзэгдэл гардаг.




Discreetly, but carefully, watch children's behaviour; the natural curiosity of children may lead to artefacts being touched or scratched, with possible consequential damage.

Хүүхдүүдийн хөдөлгөөнийг сэмхэн гэхдээ анхааралтай харж ажиглаж байх. Хүүхдийн байгалийн гэнэн сониуч зан нь үзмэрт хүрэх, хатгаж, зурах зэргээр гэмтээхэд хүргэдгийг анхаарах нь зүйтэй.




Please always remember that your primary duty is to protect the museum collection; if questioned by a visitor, give answers only related to museum facilities and rules; you are a guard, not a tourist guide.

Таны үүрэг бол музейн цуглуулгыг хамгаалах гэдгийг байнга санах учиртай. Хэрэв үзэгч асуулт тавьж хандвал та журам зааврын дагуу өөрийн үүргийн холбогдох асуултад хариулж бусад асуудлыг хэрхэх талаар зөвлөж болно. Та хамгаалалтын албаны хүн болохоос биш хөтөч тайлбарлагч биш гэдгийг мартаж болохгүй.




Keep an especially attentive eye on small items that can easily be removed, such as an antique vase cover, for instance, or ...

Эртний ваар сав зэрэг хялбар гэмтэх болон хүн авч болох жижиг үзмэрийг нүд салгалгүй харж байвал зохино.



... the hands of a clock, or...

... цагны зүү байж болно, эсвэл ...



...a key and a keyhole cover.

... түлхүүр ба түгжээний хаалт ч байж болох юм.



Be ever alert and attentive; if you need to leave your duty post for a moment, ask to be replaced.

Байнга сонор сэрэмжтэй, анхааралтай байх шаардлагатай. Хариуцсан ажлаа түр орхих тохиолдолд хэн нэгнийг заавал орлуулж үлдээх ёстой.



If no visitor is present, you may rest on appropriate collapsible chairs.

Үзэгчгүй байх үед та хариуцсан талбайн сандалд сууж амарч болох билээ.



Never rest on artefacts on show.

Үзүүллэгт дэглэн тавьсан үзмэр дээр хэрхэвч сууж болохгүй.



Be always ready to use the internal phone to call for support.

Дотоод холбооны телефон утсыг тусламж дуудахад байнга бэлэн байлгах шаардлагатай.



Be always ready to use a portable fire extinguisher.

Зөөврийн гал унтраагчийг хэрэглэхэд ямагт бэлэн байлгах шаардлагатай.



If a visitor should have an accident, ...

Хэрэв үзэгчид ямар нэг онцгой явдал тохиолдвол...



...keep other people at a distance and call for professional first aid.

... бусад хүмүүсийг ойртуулалгүй зайдуу байлгаж, яаралтай тусламж үзүүлэх, тусламж дуудах хэрэгтэй.



When the paramedics arrive, interview witnesses and record all the relevant facts.

Тусламж ирэхэд болсон явдлын тухай бүхий л зүйлийг мэдээлэх, тэмдэглэж үлдээх, гэрчүүдээс ярилцлага өгөх боломж олгох хэрэгтэй.



At appointed time, gently yet firmly escort all visitors to the exit.

Тогтоосон цагт үзэгчдийг гарах хаалгаар эелдгээр үдэж гаргана.



Strictly refrain from accepting gratuities of any kind; if appropriate, propose a donation to support museum activities.

Үзэгчээс ямар нэг гарын бэлэг авахаас зайлсхийх, музейд туслах хандивыг холбогдох ажилтнууд албан ёсоор хүлээж авах ёстой.



Put all the museum exits under lock and key.

Музей хаасаны дараа гарах бүх хаалгыг цоожилж түгжих хэрэгтэй.



Lock all windows.

Цонхнуудыг мөн хааж түгжинэ.



Inspect all exhibition rooms.

Үзүүлэгийн бүх танхимуудыг үзэж шалгах шаардлагатай.




Check all intrusion detector devices by observing the blinking light reaction to your movements (if appropriate).

Хөдөлгөөн мэдрэх илрүүлэгч төхөөрөмжийг өөрөө явж хөдөлж шалгах хэрэгтэй.




Inspect all service rooms and toilets.

Үйлчилгээний ба бие засах өрөөнүүдийг үзэж шалгах хэрэгтэй.



Check that all main keys are present or properly accounted for.

Чухал шаардлагатай түлхүүрүүд тоо ёсоор, бүтэн хэвийн байгаа эсэхийг шалгах нь зүйтэй.



Write any information about your day shift in the logbook for the information of the night guards.

Өдрийн ээлжийн хугацаанд болсон бүх үйл ажиллагааг шөний ээлжинд мэдээлэх зорилгоор мэдээний дэвтэрт дэлгэрэнгүй бичих хэрэгтэй.



Turn on the night intrusion detection control panel; check that all security equipment is working properly.

Шөнө ажиллах дохиолол хяналтын төхөөрөмжийг шалгаж, асааж бэлэн байлгавал зохино.



Perform night shift exchange of duties, according to relevant procedures.

Холбогдох зааврын дагуу шөнийн ээлжийн хамгаалалтын албанд ажил үүргээ хүлээлгэн өгөх хэрэгтэй.




If appropriate, carry out the night shift watch tour by checking the areas for inspection in the sequence indicated here.

(Хэрэв шаардлагатай бол) энэ зааварт заасан дарааллын дагуу шөнийн ээлжийн үүрэгт ажлыг хүлээлгэн өгөх хэрэгтэй.



Check the important areas once again as indicated in this handbook.

Энэ зааварт заагдсаны дагуу онцгой газруудыг дахин сайн шалгавал зохино.



If there is a watch recorder, set to planned schedule.

Дүрс бичлэгийн төхөөрөмжийг төлөвлөсөн хуваариар ажиллахад бэлэн болгож тохируулвал зохино.